



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Халзан сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: соо@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Залруулга.....	17
5.2 Төлбөрийн акт.....	17
5.3 Албан шаардлага.....	17
5.2 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА**

2023.02.25 № 122
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн “Халзан сумын цэцэрлэг”-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн “Халзан сумын цэцэрлэг”-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

Байгууллагын 9 бодлого 6 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөгөөр 344,295.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэл 98 хувь хэрэгжсэн байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын 9 бодлого 6 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөгөөр 268,614.4 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 264,658.6 мянган төгрөг буюу 98 хувь хэрэгжсэн байна. Орон нутгийн санхүүжилт 24,411.8 мянган төгрөг батлагдан 23,995.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласныг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>44,822,690.00</u>	<u>80,037,955.30</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	4,015,735.30
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	4,015,735.30
3121	Төгрөг	-	4,015,735.30
31211	Төрийн сангийн харилцах	-	4,015,735.30
35	БАРАА МАТЕРИАЛ	44,822,690.00	76,022,220.00
351	Түүхий эд материал	786,500.00	786,500.00
35130	Эм боох материал	786,500.00	786,500.00
354	Хангамжийн материал	44,036,190.00	75,235,720.00
35410	Бичиг хэргийн материал	1,738,880.00	1,589,780.00
35420	Аж ахуйн материал	36,753,090.00	68,847,090.00
35460	Хүнсний материал	592,450.00	477,300.00
35470	Бусад хангамжийн материал	4,951,770.00	4,321,550.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,163,305,856.12</u>	<u>1,151,589,011.06</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,163,305,856.12	1,151,589,011.06
392	Биет хөрөнгө	1,161,793,856.12	1,148,777,011.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,156,021,589.95	1,155,833,862.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	(29,805,419.88)	(47,298,497.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,461,030.00	53,628,030.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,857,462.79)	(28,821,237.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,001,204.50	24,088,184.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,407,754.94)	(11,034,000.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,100,000.00	4,600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,100,000.00)	(4,600,000.00)
39217	Ном	2,380,669.28	2,380,669.28
393	Биет бус хөрөнгө	1,512,000.00	2,812,000.00
39301	Програм хангамж	-	1,500,000.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,512,000.00	1,512,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,208,128,546.12</u>	<u>1,231,626,966.36</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	3,375,293.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,375,293.01
413	Өглөг	-	3,375,293.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,614,075.02
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	261,217.99
4136	Бусад өглөг	-	1,500,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,500,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,208,128,546.12</u>	<u>1,228,251,673.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,208,128,546.12	1,228,251,673.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,747,770.00	60,747,770.00
51101	Өмч: - төрийн	60,747,770.00	60,747,770.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,079,168,723.21	1,099,291,850.44
51210	Өмнөх үеийн үр дүн	-	(128,759,822.91)
51220	Тайлант үеийн үр дүн	1,079,168,723.21	1,228,051,673.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	68,212,052.91	68,212,052.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,208,128,546.12</u>	<u>1,231,626,966.36</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,325,866,897.00	1,582,099,046.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,059,981,497.00	1,238,373,546.12
120	Нийтлэг татварын бус орлого	1,059,981,497.00	1,238,373,546.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,059,981,497.00	1,238,373,546.12
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	630,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,059,981,497.00	1,237,743,546.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	265,885,400.00	343,725,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	226,668,400.00	268,044,400.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	226,668,400.00	268,044,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,017,000.00	75,681,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,017,000.00	75,681,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	352,046,231.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	352,046,231.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	345,838,464.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	207,670,474.02
210101	Үндсэн цалин	-	156,403,449.71
210102	Нэмэгдэл	-	38,819,936.96
210104	Урамшуулал	-	12,447,087.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	27,401,501.00
210201	Тэтгэврийн даатгал	-	18,633,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,192,301.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,753,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	438,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,384,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	37,998,833.34
210301	Гэрэл, цахилгаан	-	1,761,178.34
210302	Түлш, халаалт	-	35,072,155.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,165,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,303,550.00
210401	Бичиг хэрэг	-	2,194,500.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,109,050.00
2105	Нормативт зардал	-	34,335,302.69
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	310,000.00
210502	Хоол, хүнс	-	34,025,302.69
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	391,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	391,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	33,737,803.77

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,394,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	287,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	24,055,703.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,207,766.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,846,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,846,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,360,966.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,360,966.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,325,866,897.00	1,230,052,814.64
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,001,141.29
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,001,141.29
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,001,141.29)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,325,866,897.00	1,228,051,673.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	265,885,400.00	344,355,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	630,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	630,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	630,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	630,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	265,885,400.00	343,725,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	226,668,400.00	268,044,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	226,668,400.00	268,044,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	200,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,017,000.00	75,681,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,017,000.00	75,681,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	340,339,764.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	340,339,764.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	334,131,998.04

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	206,056,400.00
210101	Үндсэн цалин	-	154,789,375.69
210102	Нэмэгдэл	-	38,819,936.96
210104	Урамшуулал	-	12,447,087.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	27,401,500.00
210201	Тэтгэврийн даатгал	-	18,633,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,192,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,753,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	438,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,384,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	38,741,933.34
210301	Гэрэл, цахилгаан	-	2,444,278.34
210302	Түлш, халаалт	-	35,072,155.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,225,500.00
2105	Нормативт зардал	-	33,803,734.70
210502	Хоол, хүнс	-	33,803,734.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	16,899,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	11,900,000.00
210604	Урсгал засвар	-	4,999,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	491,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	491,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,738,230.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,568,630.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,169,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,207,766.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,846,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,846,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,360,966.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,360,966.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	265,885,400.00	4,015,735.30
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	265,885,400.00	4,015,735.30
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,015,735.30
----	---	---	--------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	60,747,770.00	68,218,052.91	1,079,162,723.21	1,208,128,546.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,747,770.00	68,218,052.91	1,079,162,723.21	1,208,128,546.12
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,747,770.00	68,218,052.91	1,079,162,723.21	1,208,128,546.12
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	60,747,770.00	68,218,052.91	1,079,162,723.21	1,208,128,546.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,207,928,546.12	-1,207,928,546.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,747,770.00	68,218,052.91	-128,765,822.91	200,000.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,228,051,673.35	1,228,051,673.35
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,747,770.00	68,218,052.91	1,099,285,850.44	1,228,251,673.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	344,295,500.00	336,978,798.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	344,295,500.00	336,978,798.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	341,448,500.00	334,131,998.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,056,400.00	206,056,400.00
210101	Үндсэн цалин	161,113,400.00	154,789,375.69
210102	Нэмэгдэл	39,713,900.00	38,819,936.96
210104	Урамшуулал	5,229,100.00	12,447,087.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,401,500.00	27,401,500.00
210201	Тэтгэврийн даатгал	18,633,100.00	18,633,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,192,300.00	2,192,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,753,600.00	1,753,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	438,300.00	438,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,384,200.00	4,384,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,102,100.00	38,741,933.34
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	2,444,278.34

210302	Түлш, халаалт	35,102,100.00	35,072,155.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	1,225,500.00
2105	Нормативт зардал	37,524,500.00	33,803,734.70
210502	Хоол, хүнс	37,524,500.00	33,803,734.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,900,000.00	16,899,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,900,000.00	11,900,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,999,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	491,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	491,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,872,000.00	10,738,230.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,622,000.00	8,568,630.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	2,169,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,847,000.00	2,846,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,847,000.00	2,846,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,847,000.00	2,846,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	343,725,500.00	343,725,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	343,725,500.00	343,725,500.00
122005	Орон нутгийн төсвөөс	343,725,500.00	343,725,500.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,376,701.96

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Халзан сумын цэцэрлэг нь “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилготой Боловсрол соёл шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал “Заавар батлах тухай”
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дугаар тушаал “Заавар батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Халзан сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Халзан сумын цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,198.4 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	4,015.7	4,015.7
Бараа материал	44,822.7	76,022.2	31,199.5
Үндсэн хөрөнгө	1,163,305.9	1,151,589.0	-11,716.8
Нийт хөрөнгийн дүн	1,208,128.5	1,231,627.0	23,498.4
Нийт өр төлбөр	-	3,375.3	-3,375.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,747.8	60,747.8	0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,208,128.5	1,231,627.0	23,498.4

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,015.7 мянган төгрөг болж, харилцах дансанд үлдсэн үлдэгдлээр мөнгөн хөрөнгө өссөн ба бараа материалын үлдэгдэл 76,022.2 мянган төгрөг болж 31,199.5 мянган төгрөг буюу 69.6 хувиар өссөн нь 29,815.0 мянган төгрөгийн тоглоом болон бусад хөрөнгө хандиваар авсантай холбоотой байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,151,589.0 мянган төгрөг болж, 11,716.8 мянган төгрөг буюу 1 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 256,232.1 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн авч нэгтгэхтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн өмчийн өөрчлөлтийн тайлан дээр үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлээс хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг хассан зөрүүг үндсэн хөрөнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дээр нэмэгдүүлсэн.

Мөн бараа материалын эхний үлдэгдлийг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого дээр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Энэ нь сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоотоор “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах” чиглэлийн дагуу өөрчлөлтүүд хийгдсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 60,674.6 мянган төгрөг буюу 21 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хоол хүнсний зардалтай холбоотой байна. Цалингийн зардал 36,328.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,695.1 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 26,308.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсвийн байгууллагаас тус байгууллагын 2022 оны төсвийг 344,295.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 264,658.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 72,320.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 630.0 мянган төгрөг нийт 839,024.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 821,756.5 мянган төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн 36.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт 344,295.5 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 268,044.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 75,681.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 630.0 мянган төгрөг бүгд 344,355.5 мянган төгрөгийн орлого бүрдэж, нийт зардалд 336,978.7 мянган төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	800.00	800.00	-	100%
2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	37,524.50	33,803.70	3,720.80	90.1%
3	81816- Зөв Монгол хүүхдийн үндэсний хөтөлбөр	1,223.00	1,223.00	-	100%

4	81823- Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	800.00	775.00	25.00	96.9%
5	81834- Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	194,207.20	193,997.40	209.80	99.9%
6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	33,489.70	33,489.50	0.20	100%
7	83602- ЗГ болон ЗД нөөц хөрөнгөөс хуваарилсан	570.00	570.00	-	100%
8	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	47,102.10	43,741.10	3,361.00	92.9%
9	80112- Нийтлэг үйлчилгээ	16,679.00	16,679.00	-	100%
10	83201- Ангилагдаагүй бусад зориулалт арга хэмжээ	11,900.00	11,900.00	-	100%
	НИЙТ	344,295.50	336,978.70	7,316.80	97.9%

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 97.9 хувьтай хэрэгжсэн байна.

Цэцэрлэгийн хүүхдийн хоол, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн өмчийн барилгын тогтмол зардал 3,361.8 мянган төгрөгөөр хэмнэгдэж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,015.7 мянган төгрөг байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Халзан сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн МНБ, аудитор Б.Бүзмаа, аудиторын туслах Л.Золбоо нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор С.Энхтөр, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Халзан сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Б/02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 3,982.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,787.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд гэрэл, цахилгааны зардал 327.4 мянган төгрөг, түлш, халаалтын зардал 2,894.0 мянган төгрөг, бичиг хэрэг, шатахууны зардал 3,438.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

- Гэрэл цахилгааны зардал өмнөх оноос дунжаар 23 хувиар нэмэгдсэн нь 2021 онд ковидын улмаас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардал бага гарч байсан бол тайланд онд үйл ажиллагаа хэвийн явагдсанаас зардал өссөн байна.
- Бичиг хэрэг, тээвэр, шатахууны зардал өмнөх оноос дунджаар 2 дахин өссөн нь бараа материалын үнэ урд оноос 2-3 дахин өссөн нь нөлөөлөл үзүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Цэцэрлэг нь 2022 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой.” заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Халзан сумын цэцэрлэгт завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжөөр өгсөн элэгдлээр өртгөө нөхсөн 64 нэр төрлийн үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч данснаас акталж, хасах буюу дахин үнэлгээ хийсэн байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100%
Нийт дүн	1	-	1	-	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 68,607.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,470.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 48,722.0 мянган төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, 263.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, нийт 6,151.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

5.1 Залруулга

Засаг даргын нөөц сангийн хөрөнгөнөөс олгосон 630.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор бүртгэсэн, худалдан авсан 12,840.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайлан болон үр дүнгийн тайланд залруулсан.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Цэцэрлэгийн хуучин барилга, төмөр хашаа, сантехникийн дотно гадна шугамын нийт 48,722.0 мянган төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр буулгасан бөгөөд данс бүртгэлд үлдэгдлээр илэрхийлэгдсэн нь дансны үлдэгдэл, холбогдох тодруулгатай холбоотой үнэлгээ ба хуваарилалт, толилуулгын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1.3, 77 дугаар зүйлийн 1, 2.3, 80 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Орон нутгийн өмчийн газарт зөрчлийг арилгах албан шаардлага өгөв

2. Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтаар батлагдаагүй 5,831.6 мянган төгрөгийн ажил гүйлгээ гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөв

5.3 Акт тогтоох

Илрүүлэлт: Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингаас НДШ, ХХОАТ-ын 263.5 мянган төгрөгийг илүү суутгасан.

Шийдвэрлэсэн: Илүү суутгасан төлбөрийг 2 ажилтанд олгох төлбөрийн акт тогтоов

5.4 Зөвлөмж

1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 4 мэдээ хугацаандаа байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбоотой мэдээ мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т заасан хугацаанд мэдээлэх;

2. Илрүүлэлт:

Тооллогын комисс тооллогыг чанартай хийж гүйцэтгээгээгүйгээс 320.0 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг орхигдуулан тоолсон байна.

Өгсөн зөвлөмж:

Тооллогыг хөрөнгө тус бүрээр эд хариуцагчийн карттай тулган, чанар, үр дүнтэй тоолж, баталгаажуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Засаг даргын нөөц сангийн хөрөнгөнөөс олгосон 630.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор бүртгэснийг залруулсан	1	630.0					1	630.0				
Худалдан авсан 12,840.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнийг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр тайлагнасныг, хөрөнгийн зардлаар бүртгүүлсэн.	1	12,840.0					1	12,840.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл													
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									Залруулга	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Цалингийн зардалд Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмжийг оруулж тооцсон боловч ХХОАТ, Нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй бүртгэл хөтөлсөн.	1	263.5	1	263.5									
Цахим төлбөрийн баримтаар батлагдаагүй ажил гүйлгээ гаргасан байна.	1	5,831.6			1	5,831.6							
Тооллогын комисс тооллогыг чанартай хийж гүйцэтгээгүйгээс зарим хөрөнгө, бараа материалыг орхигдуулан тоолсон байна.	1	320.0			1	320.0							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**/мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хугацаа хоцорч мэдээлсэн	1	0	-	-	-	-	1	0
Дүн	1	0	-	-	-	-	1	0